



### НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот


#### АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 124 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2010 оны "Ажлын хэсэг томилон ажиллуулах тухай 633 тоот Захирамжийн гуравдугаар заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Ах дүүгийн харилцаат хотуудын хооронд 2010-2012 онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр Эрхүү хотод ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд албаны дэд дарга Ч.Батсайхан, мэргэжилтэн Ч.Сэдэд нар орсон тул 2010 оны 9 дүгээр сарын 10-16-ний өдрүүдэд Оросын Холбооны Улсын Эрхүү хотод томилон ажиллуулсугай.

Хоёр. Дэд дарга Ч.Батсайхан, мэргэжилтэн Ч.Сэдэд нарын гадаад томилолтын зардлыг Сангийн сайдын тушаалыг үндэслэн тооцож олгохыг нягтлан бодогч /З.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Томилолтоор хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг 9 сарын 24ний дотор албаны дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтэст тайлагнахыг Ч.Батсайхан, Ч.Сэдэд нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХЦОГ

